

амьсгал, соёлыг төлөвшүүлэх, стрессийн удирдлага, удирдлагын сэтгэл зүй, харилцааны соёл, өөрийгөө жолоодох урлаг зэрэг хичээлийн төрөл, сэдэв зайлшгүй байх шаардлагатай гэж үзэж байна.

ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДАЛ БА ХУУЛЬ САХИУЛАХ САЛБАРЫН ЖЕНДЭРИЙН БОДЛОГО

Ж.НЯМДУЛАМ

ХСИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн
Эрх зүйн онолын тэнхимийн ахлах багш, доктор \Ph.D\,
цагдаагийн хошууч

Жендэрийн асуудал өнөө үед нийгмийн тодорхой салбарт чиглэгдэж, ялангуяа төрийн тусгай чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллага, хилийн аюулгүй байдлын албанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах, оновчтой зөв менежментээр удирдах асуудал энэ салбарын тулгамдсан асуудал болоод байна.

Олон улсын түвшинд НҮБ-ын Аюулгүйн зөвлөл, Европын холбооны улсууд Аюулгүй байдлын салбарт, тэр дундаа Хууль сахиулах салбарт жендэрийн мэдрэмжтэй хандах, эмэгтэйчүүдийн манлайллыг онцгой анхаарч, улмаар ажилтан албан хаагчдын хүний нөөцийн асуудлыг оновчтой тодорхойлох, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээнд тохирсон, ээлтэй ялгаварлан гадуурхалтгүй ажиллах орчинг бүрдүүлэх замаар хүний эрхийг хангах, тэгш байдлын зарчмыг чанд мөрдүүлэх, хууль сахиулах байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах асуудал нв салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулна гэж үзэж байна.

Миний бие Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага \ЕАБХАБ\-ын Үндэстэн дамнасан аюул заналхийлэлтэй тэмцэх газар хилийн аюулгүй байдлын асуудал хариуцсан байгууллагуудад эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх механизмыг бүрдүүлэхэд чиглэсэн “Women Leadership and Empowerment Initiative for Border Security and Management Agencies” төсөлд 2016 оноос хамрагдаж, 2016 онд Бүгд Найрамдах Финлянд, Бүгд Найрамдах Испани Улсад зохиогдсон Олон Улсын хурлуудад оролцож, түүний үр дүнг тайлагнаж 2016 онд Нийслэлийн дүргүүдийн цагдаагийн ахлах офицер эмэгтэйчүүдэд 2 өдрийн сургалт явуулж байсан. Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын Жендэрийн нэгдсэн бодлого \2018-2021 он\ баримт бичиг боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, уг баримт бичигт ХСИС-иас хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусгуулж, тус баримт бичиг 2018 онд батлагдаж, үүнтэй холбоотойгоор ХСИС-д хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Аюулгүй байдал, тэр дундаа хууль сахиулах салбарын ахлах офицер болон ахлах мэргэжилтэн албан тушаал хашиж буй дунд түвшний эмэгтэй алба хаагчдад НҮБ болон Европын холбоо, олонг улсын түвшинд энэ салбарын жендэрийн бодлогыг хэрхэн барьж байгаа, манай улсад энэ чиглэлээр баримталж буй бодлогын баримт бичгийг танилцуулж, салбарын хэмжээний эмэгтэй алба хаагчдын ялгаатай хэрэгцээг тодорхойлж, түүнд удирдлыгн зүгээс

жендэрийн мэдрэмжтэй хандуулахад чиглэгсэн санал, зөвлөмжийг боловсруулж, уламжлахад оршино.

Монгол Улс нь 2011 онд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг батлан. Ерөнхий сайдаар удирдуулсан Жендэрийн үндэсний хороо, түүний ажлын алба, салбар зөвлөл, хороод улс даяар ажиллаж эхэлснээс хойш жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр тодорхой ахиц дэвшил гарган, бүс нутагтаа манлайлж яваа билээ. Өнгөрсөн жилүүдэд уг хуулийг хэрэгжүүлэх үндэсний тогтолцоог хөгжүүлж, чадавхи бүрдүүлэх, жендэрт суурилсан хүчирхийлэл, түүний дотор гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр дорвитой ажил хийж гүйцэтгэлээ.

НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс энх тайван, аюулгүй байдал ба жендэрийн асуудлыг уялдаа холбоонд нь авч үзсэн "UNSCR 1325 (2000) Women, Peace and Security" тогтоолыг анх 2000 оны 10 дугаар сарын 20-нд баталсан. Тогтоолыг батлах хоёр үндсэн шалтгаан байсан. Нэгд, дайн байлдаан, зөрчил тэмцэлд эмэгтэйчүүд, охидод асар их хохирол, сөрөг нөлөө үзүүлдэг. Хоёрт, дайн байлдаан, зөрчил тэмцэлээс урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх, энхийг тогтоох, цогцлооход эмэгтэйчүүд маш их үүрэг гүйцэтгэдэг буюу гүйцэтгэх ёстой. Гэтэл энхийн төлөөх үйлс, энх тайван, аюулгүй байдлын асуудлаарх яриа хэлэлцээнд эмэгтэйчүүдийн төлөөлөл хангагддаггүй.

Тиймээс Аюулгүйн Зөвлөлийн 1325 дугаар тогтоолд зөрчил, тэмцлийг шийдвэрлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, энхийн яриа хэлэлцээ өрнүүлэх, энхийг цогцлоох болон сахиулах ажиллагаа, сэргээн босголтын үеийн хүмүүнлэгийн тусламж зэрэгт эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүргийг нотлохын зэрэгцээ энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах үйл хэрэгт эмэгтэйчүүдийг тэгш бөгөөд бүрэн оролцуулах боломжийг хангахын чухлыг цохон тэмдэглэсэн. НҮБ-аас Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдал (ЭЭТАБ)-ын асуудлаарх Аюулгүйн зөвлөлийн 1325 дугаар тогтоолоор Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө (ҮҮАТ) боловсруулж хэрэгжүүлэхийг гишүүн орнуудыг уриалдаг. 2018 оны 4 дүгээр сарын байдлаар 74 орон ҮҮАТ батлан хэрэгжүүлж буй.

Манай улсын хувьд Аюулгүйн зөвлөлийн 1325 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөг тусгайлан батлаагүй. Харин Монгол Улс НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл (ХЭЗ)-ийн "Universal Periodic Review" механизмын дагуу Хүний эрхийн төлөв байдлын хоёрдугаар илтгэлээ 2015 оны 5 дугаар сард хэлэлцүүлж хамгаалах үеэр нийт 64 улсаас 164 зөвлөмж ирсний 150-ыг хүлээн авсны дотор Португал Улсын "108.49 Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдлын асуудлаарх АЗ-ийн 1325 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх үндэсний төлөвлөгөө батлах асуудлыг судлан үзэх" гэсэн зөвлөмж байв. Улмаар Засгийн Газрын 2016 оны 204 дүгээр тогтоолоор "НҮБ-ын ХЭЗ-өөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө"-г баталсан юм. Ерөнхий төлөвлөгөөнд Португалын дээрх зөвлөмж 34 дүгээр заалт болон тусгагдсан.

Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг (UPR)-33С Монгол Улсад өгсөн зөвлөмжийн дунд хугацааны хэрэгжилтийн тайланг энэ

онд хэлэлцэх үеэр дээрх 1325 дугаар тогтоолын асуудлаар үндэсний төлөвлөгөө батлах заалт хэрэгжээгүй. цаашид судлах шаардлагатай асуудлын тоонд орсон байна. Тиймээс энэ асуудлын талаар НҮБ-ын баримт бичгүүд, гадаад дотоодын эх сурвалжийг ашиглан энэхүү бэсрэг танилцуулга-судалгааг бэлтгэв. Судалгаа нь оршил, дүгнэлтээс гадна НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1325 дугаар тогтоолын хэрэгжилтийн байдал, ЭЭТАБ-ын асуудлаарх ҮҮАТ боловсруулж хэрэгжүүлэхийн ач холбогдол, туршлага, сургаамж, Монгол Улсад Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах зарим хэрэгцээ ба урьдач нөхцөл гэсэн хэсгүүдээс бүрдэнэ. Мөн эхний хэсэгт энхийг сахиулах ажиллагаан дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь, үүрэг ролийн асуудлыг товч хөндсөн.

Энд Монгол улсын Хууль зүй, дотоод хэргийн яам, түүний харьяа байгууллагуудын идэвхтэй оролцоо, ажилтнуудын хүчин чармайлт, өөрслийн хувь нэмрээ оруулсаар байгааг дурьдахгүй өнгөрөх аргагүй юм. Өнөөдөр үндэсний түвшинд нэгдсэн байдлаар тодорхойлогдож ирсэн жендэрийн бодлого төлөвлөлтийг төрийн захиргааны төв байгууллага, түүний харьяа байгууллага агентлагууд, нутгийн удирдлагын байгууллагуудын бодлого төлөвлөлтөд нэвтрүүлэх, үндсэн чиг үүрэгтэй нь уялдуулан нийт ажилтан, албан хаагчдын жендэрийн хэрэгцээг шийдвэрлэх, улмаар төрийн үйлчилгээг жендэрийн мэдрэмжтэй болгох ажил улс орон даяар өрнөж байна.

Энэ нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон холбогдох бусад хуулийн хэрэгжилтийг Монгол Улсын айл өрх, иргэн бүрт хүргэж, жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхлыг нийгмийн амьдралын бүх хүрээнд таслан зогсоож, хохирогчдыг хамгаалан, гомдлыг хянан шийдвэрлэх, Тогтвортой хөгжлийн зорилтуудын Жендэрийн тэгш байдлыг хангах 5-дугаар зорилтыг хэрэгжүүлэх чухал алхам гэж үзэж болно. Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам нь үндсэн чиг үүргийнхээ хүрээнд дээрх үйл явцад тэргүүлэх үүрэг гүйцэтгэж, жендэрийн тэгш байдлыг дэмжихийн тулд яам болон түүний харьяа хууль сахиулах байгууллагуудад хэрэгжих жендэрийн нэгдсэн бодлогыг боловсруулсан. Энэхүү нэгдсэн бодлого нь хууль сахиулах байгууллагад ажиллагсадын жендэрийн ялгаатай хэрэгцээг бодлого төлөвлөлтөд тусгах, тэднийг чадавхижуулах замаар тэгш эрх, тэгш оролцоог нь хангах тогтвортой бодлогын гараа болж байна. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд жендэрийн тэгш байдлыг хангах арга хэмжээг салбарын хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх, Засгийн газраас баталсан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017-2021)-т төрийн захиргааны төв байгууллагууд нь салбартаа баримтлах жендэрийн бодлоготой байна хэмээн тусгасан.

Жендэрийн эрх тэгш байдал, түүнийг хууль сахиулах салбарт тэнцвэртэй бөгөөд уян хатан бодлогоор зохицуулах нь дан ганц эрх зүйн орчны бус нийгэм, эдийн засгийн, геополитик, сэтгэлгээний соёл зэрэг олон хүчин зүйлээс хамааралтай байж болох юм. Миний илтгэл 2 үндсэн хэсгээс бүрдэнэ.

1. Монгол Улсын хууль сахиулах салбарт жендэрийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоо;

2. Хууль сахиулахын их сургуулийн сургалтын хөтөлбөрт жендэрт суурилсан бодлогын баримт бичгийг тусгах. хичээл, сургалтанд нэмж оруулах боломж нөхцлийн талаар танилцуулга хийх.

Нэг. Монгол Улсын хууль сахиулах салбар дахь жендэрийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоо

Монгол Улсын хууль сахиулах байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хууль тогтоомжоор тогтоосон журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох. мөрдөн байцаалт, хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулахад хууль дээдлэх, хүний эрх. эрх чөлөөг хангахад чиглэгдэнэ. Манай улс 2012 онд эхлүүлсэн эрх зүйн шинэчлэлийн үр дүнд хууль сахиулах салбарын бодлого, үйл ажиллагааг ард нийт рүү чиглүүлсэн, хүний эрх, эрх чөлөөнд суурилсан, хууль дээдлэх ёсыг чанд сахихын зэрэгцээ мэргэжлийн ёс зүйг чанд сахиж, иргэд, олон нийтийн аюулгүй байдлыг хангаж, байгууллага, алба хаагчдийн хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэгдэж байна.

Энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэхэд хууль сахиулах салбарын тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, хяналт, хариуцлагын тогтолцоо нь мэргэжлийн чадавхи, материаллаг нөөц, менежментийн зөв бодлоготой салшгүй холбоотой. Хууль сахиулах байгууллагын бодлогын шийдвэр гаргах үйл явц нь тэр дундаа үйл ажиллагаа нь тушаалаар хэрэгждэг учраас албан тушаалын зэрэглэл, цолны эрэмбээр захирах, захирагдах ёсыг чанд баримтлах ёстой байдаг. Улс орнууд энэ онцлог харилцааг хэрэгжүүлэхдээ хэний ч болов эрхэмсэг оршихуйг хүндэтгэн, хүний эрхийн хандлага, арга зүйд суурилсан мэргэжлийн салбарыг бий болгож хөгжүүлэхэд анхаарч байна. Тэр дундаа энэ хүнд, өндөр хариуцлагатай салбарт эмэгтэйчүүдийн оролцоо хамгийн хэрэгтэй байгааг манай хууль зүйн яамны төрийн нарийн бичгийн дарга онцлон тэмдэглэж, хэлсэн үгэндээ "... иргэн төвтэй, иргэдэд үйлчилдэг, иргэдтэй хамтран ажилладаг хууль сахиулах байгууллагыг бий болгоход **“эмэгтэйчүүд”** хамгийн чухал үүргийг гүйцэтгэдэг...”

Хууль сахиулах салбарт зөвхөн эрэгтэй алба хаагч ажиллах нь зөв гэсэн үзэл сэтгэлгээ манай шийдвэр гаргах түвшний удирдлагад байсан үе бий. Хууль сахиулах энэ хүнд салбарт эмэгтэй алба хаагч ажиллах нь бодлогын хувьд зөв болох хандлага өнөөдөр манай салбарт байна. Учир нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10.1.2-т Төрийн захиргааны удирдах албан тушаалтны аль нэг хүйсийн төлөөлөл яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн даргын 15 хувиас, бусад төв байгууллагын удирдлагын 20 хувиас, яамдын газар, хэлтсийн даргын 30 хувиас, аймаг нийслэл, сум дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтэс, албадын даргын 40 хувиас доошгүй байх; 10.1.3. зэвсэгт хүчин, хилийн цэрэг, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, авлигатай тэмцэх болон онцгой байдлын байгууллагаас бусад байгууллагын төрийн тусгай албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байх гэсэн заалт бий. Гэтэл энэхүү заалт нь төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагад ажилладаг

эмэгтэйчүүдийн асуудлыг орхигдуулсан нь том алдаатай зохицуулалт болсон юм.

Одоогоор Монгол Улсын хууль сахиулах байгууллагад нийт 5000 гаруй эмэгтэй алба хаагч ажиллаж байнцгаа нь нийт алба хаагчдын 23 орчим хувийг эзэлж байна. Эмэгтэйчүүд иргэшсэн хууль сахиулах байгууллагыг бий болгоход нэн чухал хэрэгтэй чадваруудыг эзэмшсэн болохыг олон улсын судалгаа тогтоосон байдаг. Тодруулбал: хууль сахиулах ажиллагааг явуулахдаа “биений хүч”-нд найддаггүй. Хүч хэрэглэх, хурцадмал байдал бий болохуйц нөхцөл байдлыг намжаах буюу “гал унтраахдаа” эрэгтэй хууль сахиулагчдаас илүү чадварлаг, үр дүнтэй. Нөгөөтэйгүүр асуудалд хүлээцтэй, тайван хандаж, шийдвэр гаргахдаа алсыг харсан байдаг онцлогтой байна.

2015 онд хууль сахиулах салбарт эмэгтэй алба хаагч ажиллах боломж, нөхцөлийн талаар Монгол Улсын хууль зүйн яам, жендэрийн үндэсний хороо, НҮБ-ын хүн амын сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр орооцоонд суурилсан жендэрийн үнэлгээг ХЗЯ-ны харьяа агентлагууд болох Хил хамгаалах байгууллага, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, иргэний харьяат, шилжилт хөдөлгөөний байгууллагад явуулсан.

Уг тайлангийн дүнд манай улсын тусгай чиг үүрэг бүхий байгууллагад жендэрийн бодлого зайлшгүй хэрэгтэй байгаа нь харагдсан бөгөөд энэ бодлогыг хэрэгжүүлэхэд эхний ээлжинд удирдлагын менежментийг жендэрт суурилсан нэгдсэн стратеги бодлого боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хууль сахиулах салбарт эмэгтэй удирдах албан тушаалтан ховор байдаг нь эмэгтэйчүүдийн асуудлыг ойлгож, тэдэнд үлгэр дууриалал үзүүлэх, сургаж зөвлөх, тодорхой шийдвэр гаргахдаа тэдний эрхийг хүндэтгэхгүй байх явдал ихээхэн байдаг. Гэхдээ би хууль сахиулах салбарт удирдах албан тушаалтан заавал эмэгтэй хүйсийн хүн байж ижил хүйсийн асуудлыг ойлгож шийдвэрлэнэ гэж явцуу утгаар хэлээгүй бөгөөд ямар ч хүйсийн хүн шийдвэр гаргах бодлого, үйл ажиллагаандаа аль нэг хүйсийн эрх тэгш байх зарчмыг баримталж, тэднийг албан үүргээ гүйцэтгэхтэй холбоотой тулгарч болох хүйсийн бэрхшээлийг урьдчилан харж, шийдвэр гаргах ёстой гэж хэлэх байна. Манай улсад дөнгөж хууль сахиулахын их сургууль төгссөн сонсогчийг тушаалаар хөдөө орон нутагт томилоход \хэрэв эмэгтэй хүйсийн сонсогчийн тухайд\ уг хүн тухайн албанд томилогдон очоод ажиллах ажлын наад захын тав тухтай орчин, эрүүл ахуйн болон аюулгүй байдлын баталгаа муу байдаг. Иймээс бид энэ асуудлыг тусгай чиг үүрэг бүхий албаны ажилтан бэлтгэдэг Хууль сахиулахын их сургуулийн сургалтын хөтөлбөрт жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрийн мэдрэмжтэй алба хаагч бэлтгэх хөтөлбөр, сургалтын явуулах хэрэгтэй болоод байна.

***Хоёр. Хууль сахиулахын их сургуулийн сургалтын хөтөлбөрт
жөндөрт суурилсан бодлогын баримт бичгийг тусгах, хичээл,
сургалтанд нэмж оруулах боломж нөхөл***

Хууль сахиулахын их сургуулийн сургалтын үзэл баримтлалын зорилго нь төрийн тусгай албаны мэргэжлийн өндөр боловсрол, цогц чадамж бүхий, үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжилтэн бэлтгэн гаргах ХСИС-ийн эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн үйл ажиллагааны зорилгыг хангахад оршино. Хууль сахиулахын их сургуулийн сургалтын бодлого, чиглэл нь үйл ажиллагаагаа мэргэшсэн, үр чадвартай боловсон хүчин бэлтгэхэд гол анхаарлаа хандуулдаг ч суралцагчийн онцлог, хүйсийн тэгш байдлын харьцааг бодлогын баримт бичигтээ тусгаагүй байна.

Хууль сахиулахын их сургуульд элсэн суралцахыг хүссэн эрэгтэй, эмэгтэй хүйсийн хүмүүс элсэн орох албаны онцлог байдлыг төдийлөн сайн ойлгоогүй өсвөр насны 17-19 насны хүмүүс байдаг. Тэд ихэвчлэн аав ээжийн зөвлөгөө, сайн цагдаа, мөрдөгч болно гэсэн мөрөөдлөөр орж ирж байна. Хүйсийн хувьд сүүлийн 10-д жил эмэгтэй сонсогч элсүүлэхгүй байх, эсвэл цөөн тооны квоттойгоор элсүүлж байна. Харин Хууль зүйн яамны төрийн нарийн бичгийн дарга сүүлийн 2 жилд энэ асуудалд онцгой анхаарч эмэгтэй сонсогч элсүүлэх асуудалын квотыг нэмэгдүүлж, хүйсийн тэгш байдлыг хангахад нааштай шийдвэр гаргаж байна.

САНАЛ: Манай Улсад Хууль сахиулах салбарт нэн яаралтай Жөндөрийн стратеги боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүний тулд:

1. ХЗДХЯ, түүний харьяа болон хууль сахиулах үүрэг бүхий байгууллагуудын жөндөрийн асуудлаарх мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, бодлого төлөвлөлтөндөө жөндөрийн дүн шинжилгээ хийж, ашиглах чадавхийг дээшлүүлэх,

2. Хууль сахиулахын их сургууль Монгол Улсад хууль сахиулах салбарын алба хаагчдыг бэлтгэдэг цор ганц сургуулийн хувьд сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт зайлшгүй жөндөрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэгдсэн сургалт явуулах, анхан шатны жөндөрийн мэдлэг олгох, цаашилбал удирдах ажилтан бэлтгэдэг ХСИС-ийн удирдлагын сургуулийн хөтөлбөр, төлөвлөгөөнд жөндөрийн мэдрэмжтэй удирдах ажилтан бэлтгэхэд онцгой анхаарах.

3. Үндэсний хууль тогтоомж, эрх зүйн актуудыг Жөндөрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн зарчимд нийцүүлэн, хууль хэрэгжих эрх зүйн нэгдмэл орчинг бүрдүүлэхэд чиглэгдэнэ. Хууль зүйн салбарын хэмжээнд жөндөрийн чиг баримжаатай байхын эхний алхам нь бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид, албан хаагчид жөндөрийн мэдрэмжтэй, мэдлэгтэй байх явдал гэж үзэж байна.